

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2021.08.03 №

26

Г Асуулт тавих тухай

Ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 33/A/63 дугаар бүхий хамтарсан тушаалаар "Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журам" батлагдсан. Энэхүү журмын хэрэгжилтийн явц, гарч байгаа үр нөлөө тодорхойгүй байна. Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журмыг хэрэгжүүлэх хүрээнд хэдэн иргэн, байгууллагаас ирүүлсэн мэдээллийг хүлээн авч, хянан шалгаж буруутай этгээдэд торгууль, нөхөн төлбөр оногдуулсан талаарх тоо баримтыг аймаг, дүүрэг тус бүрээр;
2. Мэдээлэл өгсөн хэдэн иргэн, байгууллагад хэчинээн төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон талаар;
3. Дээрх журмын дагуу олгох мөнгөн урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлж байгаа талаар тус тус мэдээлэл бэлтгэн ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хувийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

НАЯНТАЙН ГАНИБАЛ

